УЛААНБААТАР ХОТ

“Хүн ам зүй, шилжилт хөдөлгөөн ба хэрэгцээ шаардлага” Түргэвчилсэн судалгаа

2022 оны 9-р сараас 2023 оны 2-р сар
(Гуравдугаар ээлжийн тоон мэдээлэл нэгтгэл)

DTM
IOM DISPLACEMENT TRACKING MATRIX

IOM
UN MIGRATION

Schweizerische Eidgenossenschaft
Confédération suisse
Confederazione Svizzera
Confederaziun svizra

Swiss Agency for Development and Cooperation SDC
Швейцарын хөгжлийн агентлаг

АГУУЛГА

Удиртгал ба арга зүй....1
1. Мэдээллийн дүн шинжилгээ - Улаанбаатар....4
1.1 Хүн амын суурь тоон үзүүлэлт ба хүн ам зүйн тойм....4
1.2 Бүртгэл....5
1.3 Ирсэн иргэд....6
1.4 Явсан иргэд....9
1.5 Хөдөлмөр эрхлэлт....11
1.6 Санхүүгийн нөхцөл байдал....12
1.7 Шилжилт хөдөлгөөнтэй холбоотой тулгамдаж буй асуудлууд....14
1.8 Үйлчилгээний хүртээмж ба дэд бүтэц....16
Дүгнэлт ба Зөвлөмж....19

УДИРТГАЛ БА АРГА ЗҮЙ

УДИРТГАЛ

Энэхүү судалгаа нь Улаанбаатар хотын хүн ам зүй, шилжилт хөдөлгөөн ба хэрэгцээ шаардлагыг тодорхойлоход чиглэсэн үндсэн сэдвүүдийн хүрээнд 2022 оны 9-р сараас 2023 оны 2-р сарын тойм мэдээллийг харуулсан болно. Уг судалгаа нь Монгол дахь ОУШХБ-аас Улаанбаатар хотод хийсэн хөдөлгөөнийг тандах ДТМ судалгааны аргачлалын гурав дахь удаагийн тоон мэдээлэл нэгтгэлийн үе шат юм.

Хоёрдугаар шатны тоон мэдээлэл нэгтгэлийн адил энэхүү судалгаагаар Улаанбаатар хотын хэмжээнд хүн амын бодит тоон мэдээлэл, суурь тоон үзүүлэлт, шилжин ирэгсэд ба явагсад (шилжилт хөдөлгөөн), хөдөлмөр эрхлэлт, санхүүгийн нөхцөл байдал, шилжилт хөдөлгөөнтэй холбоотой тулгамдаж буй асуудлууд, үйлчилгээний хүртээмж болон дэд бүтэц гэсэн найман үндсэн сэдвийг авч үзсэн болно. Тоон мэдээллийг Улаанбаатар хотын хамгийн жижиг засаг захиргааны нэгж болох хэсгийн нутаг дэвсгэрийн нөхцөл байдал, мэдээлэл нэгтгэгчийн мэдлэгийн нөөц бололцоо, мэдээллийн нээлттэй байдлаас хамааран хэсгийн[1] ахлагч нараар тандалт судалгаа, ярилцлага хийх замаар нэгтгэсэн болно.

Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллага (ОУШХБ)-ын өмнөх судалгаануудаас харахад газрын доройтол, уур амьсгалын өөрчлөлт зэрэг хүчин зүйлс Монгол Улсын уламжлалт амьдралын хэв маягийг өөрчилж байгааг бидний хийсэн өмнөх судалгаанууд тогтоосоор байна. Ган, зудын[2], давтамж нэмэгдэж, ажлын байр цөөн, амьдрах орчин нөхцөл хангалтгүй, хөдөөгийн хүн амын мал аж ахуйгаас хараат байдал зэрэг нь суурин газар болон бусад аймаг[3] орон нутаг руу чиглэсэн шилжилт хөдөлгөөнийг нэмэгдүүлэх хүчин зүйл болсоор байна.

Тэдгээр шилжих хөдөлгөөний үндсэн шинж чанарыг ойлгоход Монгол Улсын хэмжээнд өөр өөр байршилд ажиллаж амьдарч, шилжилт хөдөлгөөнд оролцож буй хүн амын бодит тоон мэдээлэл шаардагдах бөгөөд мэдээллийн зөрүүтэй байдал үндсэн шинж чанарыг ойлгоход саад болж байна. Энэхүү судалгаа нь Улаанбаатар хотын хүн ам, шилжилт хөдөлгөөний бодит мэдээллийг олж авах замаар энэ хоёр мэдээлэл хоорондын зөрүүг арилгаж дотоодын шилжилт хөдөлгөөний талаарх бодлого, үйл ажиллагааг бодит мэдээллээр хангах зорилготой.

СУДАЛГААНЫ АРГАЧЛАЛ

Судалгаанд Улаанбаатар хотын хамгийн жижиг засаг захиргааны нэгж болох хэсгийн түвшинд хэсгийн ахлагч нараас мэдээллийг нэгтгэсэн. Хэсгийн ахлагч нар иргэдтэй ярилцах, ажиглалт хийх болон өөрсдийн нөөц бололцоо болон харилцаа холбооны хэрэгслүүдийг ашиглан тоон мэдээллийг нягтлах, баталгаажуулах ажлыг хийхээр төлөвлөсөн. Хэсгийн ахлагч нарыг уг судалгааны хэсэг тус бүрээр нь танилцуулсан найман үндсэн сэдвийг багтаасан судалгааны агуулгыг/хэрэгслийг бөглөхийг хүссэн юм. Тэд Кобо программ хангамжаар дамжуулан тоон ажиглалт, баталгаажуулалт хийгдсэн мэдээллийг гар утас эсвэл таблет ашиглан нөхөж илгээсэн. Мэдээллийг зөв, чанартай нэгтгэхийн тулд судалгааг хэрэгжүүлэхээс өмнө хэсгийн ахлагч нарыг судалгааны хэрэгслийн дэлгэрэнгүй сургалтад хамруулсан.

Өгөгдлийг системд нэгтгэх үйл явц албан ёсоор хаагдмагц ДТМ-ын баг бүрэлдэхүүн тоон мэдээлэлд нэн даруй дүн шинжилгээ хийх ажлыг эхлүүлсэн бөгөөд гарч болзошгүй алдаа, тоон мэдээллийн зөрүү, давхардал зэргийг илрүүлэхийн тулд өгөгдлийн хяналтын шатанд чанарын баталгаажуулалтын шалгалтыг хийсэн. Бүх хяналт шалгалтыг хийж дуусаны дараа мэдээлэлд дүн шинжилгээ хийх үе шатанд шилжсэн. Бүх судалгааны үр дүнг хэсгийн түвшинд дүн шинжилгээ хийж дараа нь хороо[4], дүүрэг, хотын түвшинд нэгтгэн дүгнэв. Иймээс дүүрэг эсвэл хотын түвшинд энэхүү тайланд тусгагдсан аливаа үр дүнг хэсгийн түвшинд нягтлан харах боломжтой гэдгийг дурдах нь зүйтэй юм.

[1] Хэсэг гэдэг нь Улаанбаатар хотын нутаг дэвсгэрийн хамгийн жижиг засаг захиргааны нэгж юм.

[2] Зуд гэдэг нь зуны дэлгэр цагт бороо хур дутмаг, тариа ногоо ургац муутай гандуу байсантай холбогдуулан өвөл өвс тэжээл дутагдах, мал идэх өвсгүй болж өвөлжилт хүндрэхийг хэлнэ.

[3] Аймаг гэдэг нь Монгол Улсын хөдөө орон нутгийн засаг захиргааны анхдагч нэгжийг хэлнэ.

[4] Хороо гэдэг нь Улаанбаатар хотын засаг захиргааны нэгж юм.

ХЯЗГААРЛАГДМАЛ БАЙДАЛ

Энэхүү судалгаанд ашигласан аргачлал нь үндсэн мэдээлэгч нараас өгсөн мэдээлэлд дүн шинжилгээ хийж байгаа төдийгүй бусад эх сурвалжтай гурвалсан өгөгдлийн санг бий болгох үндсэн зорилготой юм.

Нэгтгэсэн өгөгдөл нь гол мэдээлэгч нарын мэдлэгт тулгуурласан ажиглалт, тооцоолол, төсөөллийг илэрхийлдгээрээ ялгаатай юм. Тиймээс өгөгдлийн найдвартай байдал нь ажиглалтын нэгжийн хэмжээ (жишээ нь, хэсгийн хэмжээ, хүн ам), хэсгийн ахлагчийн иргэдтэй хэр ойр холбоотой, ажиглалт, тоон мэдээлэлд дүн шинжилгээ хийх чадвар гэх мэт хүчин зүйлсээс хамаарч ялгаатай байх тул өгөгдлийн гадаад болон дотоод хүчин төгөлдөр байдал хязгаарлагдмал юм.

Нэмж дурдахад, тоон мэдээллийн үр дүнгийн гурвалжинд тусгасан үнэлгээ нь тухайн ажиглалт хийсэн байршилд зөвхөн нэг гол мэдээлэгчээс авсан мэдээллээр хязгаарлагдсан болно.

ГАЗАР ЗҮЙН ХАМРАХ ХҮРЭЭ



Дүүрэг	Хэсгийн тоо	Хүн амын тоо *(Бүртгэлгүй түр оршин суугчид багтсан)*
Баянзүрх	508	420,793
Сонгинохайрхан	387	352,410
Баянгол	268	259,931
Хан-Уул	230	249,172
Чингэлтэй	212	146,747
Сүхбаатар	181	137,655
Налайх	50	42,406
Багануур	34	27,105
Багахангай	6	4,539
Нийт	1,876	1,640,758

НЭР ТОМЬЁОНЫ ТОДОРХОЙЛОЛТ

Хүн амын суурь тоон үзүүлэлт: Гарал үүсэл, бичиг баримтын байдал, хууль эрх зүйн нөхцөл байдал, бүртгэл, нас, хүйс, нийгэм-хүн ам зүйн бусад шинж чанараас үл хамааран үнэлгээ хийх үед тухайн байршилд байгаа бүх оршин суугч.

Өрх: Нэг дээвэр дор амьдардаг, зардал болон хоол хүнсээ хуваалцдаг бүлэг хүмүүс.

Ирсэн иргэд: Улаанбаатар хот дотор эсвэл хотын гаднаас ирсэн эсэхээс үл хамааран хамгийн багадаа дөрвөн долоо хоног оршин суух зорилготой ямар нэг байршилд ирсэн хүмүүс (шилжилт хөдөлгөөн, түр оршин суух бүртгэл зэргийг хийлгэсэн эсэхээс үл хамаарна).

Явсан иргэд: Улаанбаатар хот дотор эсвэл хотын гаднаас явсан эсэхээс үл хамааран хамгийн багадаа дөрвөн долоо хоногийн туршид буцах бодолгүй, явсан хүмүүс (шилжилт хөдөлгөөн, түр оршин суух бүртгэл зэргийг хийлгэсэн эсэхээс үл хамаарна).

Мэдээлэгч: Мэдээллийн эх сурвалж бөгөөд энэ судалгаанд хэсгийн ахлагч нарыг хэлнэ.

Мэдээлэл нэгтгэгч: Мэдээлэл нэгтгэж буй хүн. Энэхүү үнэлгээнд гол мэдээлэгч нар мэдээлэл нэгтгэсэн тул эдгээр хоёр нэр томьёо давхцаж байна.

1. МЭДЭЭЛЛИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭ

1.1 ХҮН АМЫН СУУРЬ ТООН ҮЗҮҮЛЭЛТ БА ХҮН АМ ЗҮЙН ТОЙМ

474,198
Өрх

1,640,758
Хүвь хүн

53%
Эмэгтэйчүүд

35%
Хүүхэд

27,666
Хөгжлийн бэрхшээлтэй иргэн

13,138
Асран хамгаалагчгүй ахмад настан

12,027
Жирэмсэн эмэгтэй

15,119
Эцэг, эхийнхээ аль нэгээс тусгаарлагдсан хүүхэд

21,151
Өрх толгойлсон эцэг, эхтэй өрх

55,004
60 ба түүнээс дээш насны өрхийн тэргүүлэгчтэй өрх

Зураг 1. Хүн ам зүй (эзлэх хувь, насны бүлгээр)



Үнэлгээ хийх үед (2022 оны 9 дүгээр сараас 2023 оны 2 дугаар сар), Улаанбаатар хотод 1,640,758 иргэн, 474,198 өрх амьдарч байсан. Үүнээс 47 хувь нь эрэгтэй, 53 хувь нь эмэгтэй байв. Хүн амын 35 хувь нь хүүхэд гэж бүртгэгдсэнээс 12 хувь нь 0-5 насны, 23 хувь нь 6-17 насныхан байна. Хүн амын 56 хувийг 18-59 насны насанд хүрэгчид, 9 хувийг 60-аас дээш насны ахмад настнууд эзэлж байна.

Нийтдээ 27,666 хүн хөгжлийн бэрхшээлтэй (хүн амын 2 хувь), 12,027 эмэгтэй жирэмсэн (эмэгтэйчүүдийн 1 хувь), 13,138 ахмад настан (60 ба түүнээс дээш насныхны 9 хувь), 15,119 хүүхэд эцэг, эхийн аль нэгээс эсвэл аль алинаас тусгаарлагдсан (18-аас доош насны хүүхдүүдийн 3 хувь) гэж бүртгэгджээ. Түүнчлэн, Улаанбаатар хотын хэмжээнд 21,151 өрх толгойлсон эцэг, эхтэй өрх (нийт өрхийн 4 хувь), 60 ба түүнээс дээш насны өрхийн тэргүүлэгчтэй 55,004 өрх[5] (нийт өрхийн 12 хувь) тус бүр бүртгэгдсэн байна.

Улаанбаатар хот 9 дүүрэгтэй. Хотын хэмжээнд хамгийн олон хүн амтай гурван дүүрэгт Баянзүрх (нийт хүн амын 26 хувь), Сонгинохайрхан (21 хувь), Баянгол (16 хувь) багтжээ. Харин хамгийн цөөн хүн амтай гурван дүүрэг нь Налайх (нийт хүн амын 3 хувь), Багануур (2 хувь), Багахангай (нийт хүн амын 0.3 хувь) байв.

Зураг 2. Хүн ам зүй, дүүргээр (эзлэх хувь)



1.2 БҮРТГЭЛ

Улаанбаатар хотын нийт хэсгүүдийн 39 хувь нь 90-ээс дээш хувийн бүртгэлтэй байсан ба үүнд бүх оршин суугчид нь бүртгүүлсэн 4 хувь буюу 83 хэсэг орсон. Мөн түүнчлэн Улаанбаатар хотын нийт хэсгүүдийн 50 хувь нь ихэнх иргэд оршин суугаа газартаа бүртгэлээ хийлгэсэн (61-89 хувь), нийт хэсгийн 8 хувийн нь тал нь оршин суугаа газартаа бүртгэлээ хийлгэсэн (40-60 хувь) гэж мэдээлсэн бол үлдсэн 3 хувь нь оршин суугчдын 40-өөс доош хувь нь оршин суугаа газартаа бүртгэлээ хийлгэсэн гэж мэдээлжээ. Үүнд оршин суугаа газартаа бүртгэлээ хийлгэсэн нэг ч оршин суугчгүй 6 хэсэг багтсан болно.

Зураг 3. Оршин суух бүртгэл (хэсэгт эзлэх хувь)



[5] Өрхийн тэргүүн нь 60 ба түүнээс дээш насны хүнтэй өрх

Зураг 4. Оршин суух бүртгэл 100% хийгдсэн (дүүрэгт эзлэх хувь)

Зураг 5. Оршин суух бүртгэл 0-10% хийгдсэн (дүүрэгт эзлэх хувь)



Улаанбаатар хотын бүх дүүргүүдэд бүртгэл хийлгээгүй үндсэн шалтгаан өөрсдийгөө тухайн хэсэгт түр зуур оршин сууж байгаа гэж үзэж буй иргэд байсан ба энэ нь хотын хэмжээнд (хэсгүүдийн 26 хувь) бүртгэл хийлгэхгүй байх гол шалтгаан болсон. Бүртгүүлэхгүй байх бусад шалтгаанд бүртгүүлээд ямар нэгэн ашиг тус байхгүй гэж үздэг иргэд (14 хувь), сургууль/боловсрол эзэмших (14 хувь), бүртгэлийн маягтуудыг хэрхэн бөглөхийг мэдэхгүй (13 хувь), бүртгэлийн маягтыг бөглөхөд хэт төвөгтэй (10%) гэсэн шалтгаанууд багтжээ.

Зураг 6. Бүртгэл хийлгэхгүй байгаа үндсэн шалтгаан (эзлэх хувь)

Зураг 7. Түр зуур оршин сууж байгаа гэж үзэн бүртгэл хийггэдэггүй иргэд хамгийн ихээр мэдээлэгдсэн хороод (эзлэх хувь)

1.3 ИРСЭН ИРГЭД

Судалгааг явуулахаас өмнөх сүүлийн зургаан сарын хугацаанд Улаанбаатар хотод нийт 43,784 иргэн ирсэн байна. Ирсэн иргэдийн хамгийн өндөр хувийг Хан-Уул дүүрэг (хотын хэмжээнд нийт ирэгсдийн 26 хувь), үүний дараа Баянзүрх дүүрэг (19 хувь), Сонгинохайрхан дүүрэг (16 хувь) эзэлжээ.

Зураг 8. Ирсэн хөдөлгөөн хамгийн их бүртгэгдсэн дүүргүүд (эзлэх хувь)

Зураг 9. Хан-Уул дүүрэгт ирсэн хөдөлгөөн хамгийн их бүртгэгдсэн хороод (эзлэх хувь)



Зураг 10. Баянзүрх дүүрэгт ирсэн хөдөлгөөн хамгийн их бүртгэгдсэн хороод (эзлэх хувь)



Зураг 11. Сонгинохайрхан дүүрэгт ирсэн хөдөлгөөн хамгийн их бүртгэгдсэн хороод (эзлэх хувь)



Зураг 12. Баянгол дүүрэгт ирсэн хөдөлгөөн хамгийн их бүртгэгдсэн хороод (эзлэх хувь)



Зураг 13. Сүхбаатар дүүрэгт ирсэн хөдөлгөөн хамгийн их бүртгэгдсэн хороод (эзлэх хувь)



Улаанбаатар хотод ирсэн иргэдийн дийлэнх буюу 69 хувь нь нийслэлийн өөр дүүрэг/хорооноос ирсэн бол үүний араас хөдөө орон нутгаас ирэгсэд (16 хувь), тус дүүргийн өөр хороо/хэсгээс ирэгсэд (15 хувь) оржээ. Түүнчлэн Улаанбаатар хотын өөр дүүрэг/хорооноос ирсэн иргэдийн 50 хувь нь орон сууц зонхилсон хэсгүүдээс, 39 хувь нь гэр хороолол[6] зонхилсон хэсгүүдээс ирсэн бол үлдсэн 11 хувь нь гэр хороолол болон орон сууц холимог хэсгүүдээс ирсэн байна.

Хөдөө орон нутгаас ирсэн иргэдийн 45 хувь нь аймгийн төвийн багуудаас , 45 хувь нь сумын төвийн багуудаас, 3 хувь нь хөдөөгийн багуудаас[7] ирсэн байв.

Бүдүүвч 1. Ирсэн хөдөлгөөний төрөл (эзлэх хувь)

[6] Гэр хороолол гэдэг нь төвийн халаалт, усаар хангагдаагүй, усаа худгаас зөөвөрлөж, мод, нүүрс түлж халаалтаа авдаг монголын уламжлалт амьдрах орчныг хэлнэ. Орон сууц нь төвийн халаалт, ус хангамжид холбогдсон байдаг. Гэр хороолол болон орон сууц холимог хэсэгт эдгээр хоёр амьдрах орчин хамтран оршдог.

[7] Баг гэдэг нь хөдөө орон нутаг дахь засаг захиргааны хамгийн жижиг нэгж.

Бүдүүвч 2. Ирсэн хөдөлгөөний төрөл (эзлэх хувь)



Бүдүүвч 3. Хөдөө орон нутгаас ирсэн хөдөлгөөний төрөл (эзлэх хувь)



Улаанбаатар хотын хэмжээнд 172 иргэн отор нүүдэл[8] хийх зорилгоор ирсэн байна. Хоёрдугаар ээлжийн үнэлгээний үзүүлэлттэй (1,414 иргэн) харьцуулбал отор нүүдэл хийх зорилгоор ирэгсдийн тоо мэдэгдэхүйц буурсан байна. Отор нүүдэл хийх зорилгоор ирэгсэд бүх долоон дүүрэгт бүртгэгдсэн ба дийлэнх буюу 33 хувь нь Чингэлтэй дүүрэгт ирсэн бол үүний араас Баянгол дүүрэг (22 хувь), Хан-Уул дүүрэг (19 хувь) тус бүр орсон байна.

Отор нүүдлээр ирсэн иргэдийн үндсэн шалтгаан нь явсан хэсэгт бэлчээрийн гарц байхгүй (отор нүүдэл хийх үндсэн шалтгаанаар ирэгсэдтэй хэсгүүдийн 39 хувийн мэдээлснээр) гэсэн бол үүний дараа улирлын чанартай хөдөлгөөнд оролцох (32 хувь), энэ хэсэг дэх бэлчээрийн гарц илүү сайн (24 хувь), өөрийн багт ган, зуд нүүрлэсэн (5 хувь) гэсэн шалтгаан бүртгэгдсэн байна.

Зураг 14. Отор нүүдлийн хөдөлгөөн бүртгэгдсэн хороод (эзлэх хувь)

Бүдүүвч 4. Отор нүүдлийн үндсэн шалтгаан (эзлэх хувь)

Улаанбаатар хотод отор нүүдлийн бус шалтгаанаар ирэгсдийн хувьд боловсролын шалтгаан (22 хувь) зонхилох шалтгаан хэвээр байсан ба үүний араас хөдөлмөр эрхлэлт (18 хувь), орон сууц, газар эзэмших (16 хувь) шалтгаан байсан нь хоёрдугаар ээлжийн тоон мэдээлэл нэгтгэлийн үр дүнтэй адил байна. Харин хөдөлмөр эрхлэх үндсэн шалтгаанаар ирэгсдийн хувьд барилга (24 хувь), нийгмийн ажил (20 хувь), боловсролын салбар (14 хувь) зонхилох салбар байжээ.

Түүнчлэн энэ удаагийн үнэлгээгээр үйлчилгээний хүртээмж гэсэн шалтгаан нь өмнөх үнэлгээний 11 хувь гэсэн үзүүлэлтээс 14 хувь болж өссөн байна.

[8] Отор нь хол газар удаан хугацаагаар малаа маллан нүүдэллэхийг хэлнэ.

Зураг 15. Отор нүүдлийн бус шилжилт хөдөлгөөнд оролцох болсон үндсэн шалтгаан (эзлэх хувь)

Зураг 16. Хөдөлмөр эрхлэх үндсэн шалтгаанаар ирэгсдийн хөдөлмөр эрхлэлтийн үндсэн салбарууд (эзлэх хувь)

Хүснэгт 1. Ирсэн үндсэн шалтгаан (дүүргээр)

● I дэх чухал ирсэн шалтгаан, отор нүүдлийн бус ● II дахь чухал ирсэн шалтгаан, отор нүүдлийн бус

Нийт	Баянзүрх дүүрэг	Сонгинохайрхан дүүрэг	Баянгол дүүрэг	Хан-Уул дүүрэг
Боловсрол	Боловсрол	Боловсрол	Боловсрол	Боловсрол
Хөдөлмөр эрхлэлт	Хөдөлмөр эрхлэлт	Хөдөлмөр эрхлэлт	Орон сууц, газар эзэмших	Орон сууц, газар эзэмших
Чингэлтэй дүүрэг	**Сүхбаатар дүүрэг**	**Налайх дүүрэг**	**Багануур дүүрэг**	**Багахангай дүүрэг**
Боловсрол	Боловсрол	Хөдөлмөр эрхлэлт	Боловсрол	Боловсрол
Хөдөлмөр эрхлэлт	Орон сууц, газар эзэмших	Боловсрол	Эрүүл мэнд	Гэр бүл

1.4 ЯВСАН ИРГЭД

Тоон мэдээлэл нэгтгэх судалгааны гуравдугаар үе шат эхлэхээс өмнөх зургаан сарын хугацаанд Улаанбаатар хотоос 24,855 иргэн явсан байна[9]. Явсан иргэдийн хамгийн өндөр хувь нь Сонгинохайрхан (20 хувь), Баянзүрх (19 хувь), Баянгол дүүрэгт (15 хувь) бүртгэгджээ.

Явсан иргэдийн дийлэнх буюу 81 хувь нь Улаанбаатар хотын өөр дүүрэг рүү, 16 хувь нь дүүргийнхээ өөр хороо/хэсэг рүү, 3 хувь нь хөдөө орон нутаг руу явжээ. Улаанбаатар хотын өөр дүүрэг, хороо/хэсэг рүү явсан иргэдийн 59 хувь нь орон сууц зонхилсон хэсгүүд рүү, 22 хувь нь гэр хороолол болон орон сууц холимог хэсгүүд рүү, 19 хувь нь гэр хороолол зонхилсон хэсгүүд рүү нүүжээ. Харин хөдөө орон нутаг руу явагсдын 53 хувь аймгийн төвийн баг руу, 29 хувь нь сумын төвийн баг руу, 18 хувь нь хөдөөгийн баг руу явсан байна.

[9] Явсан иргэд гэдэг нь Улаанбаатар хотын аль байршлыг орхиж явснаас үл хамааран хотын нэг цэгээс нөгөө цэг рүү, эсвэл орон нутаг, гадаад улс оронд явсан иргэд, айл өрхийг хэлнэ. Мөн түүнчлэн энэхүү тоон мэдээлэл нь хэсгийн ахлагчийн мэдлэг, тандалт судалгаан дээр үндэслэн тооцоолсон тоо тул бодит тоон мэдээллээс зөрүүтэй байх боломжтой юм.

Зураг 17. Явсан хөдөлгөөн хамгийн их бүртгэгдсэн дүүргүүд (эзлэх хувь)

Бүдүүвч 5. Явсан хөдөлгөөний төрөл (эзлэх хувь)



Бүдүүвч 6. Улаанбаатар хот доторх явсан хөдөлгөөний төрөл (орон байрны төрөл)



Бүдүүвч 7. Хөдөө орон нутаг руу явсан хөдөлгөөний төрөл (эзлэх хувь)

Зураг 18. Явсан хөдөлгөөний үндсэн шалтгаан (эзлэх хувь)

Улаанбаатар хотын хэмжээнд явсан хөдөлгөөний үндсэн шалтгаан боловсрол (24 хувь) гэсэн нь хоёр дугаар эзлжийн тоон мэдээлэл нэгтгэлийн үр дүнтэй адил хэвээр байна. Мөн түүнчлэн орон сууц, газар эзэмших (20 хувь), хөдөлмөр эрхлэлт (18 хувь), үйлчилгээний хүртээмж (13 хувь) гэсэн үндсэн шалтгаанууд бүртгэгджээ. Харин өмнөх үнэлгээгээр 10 хүрэхгүй хувьтай байсан эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмж шалтгаан нь энэ удаагийн үнэлгээгээр нийслэл хотоос явах тав дахь үндсэн шалтгаан болж 11 хувь болсон үзүүлэлттэй байна.

Хүснэгт 2. Явсан шалтгаан (дүүргээр)

● Явсан анхдагч шалтгаан ● Явсан хоёрдогч үндсэн шалтгаан

Нийт	Баянзүрх дүүрэг	Сонгинохайрхан дүүрэг	Баянгол дүүрэг	Хан-Уул дүүрэг
Боловсрол	Боловсрол	Хөдөлмөр эрхлэлт	Орон сууц, газар эзэмших	Боловсрол
Орон сууц, газар эзэмших	Орон сууц, газар эзэмших	Боловсрол	Боловсрол	Орон сууц, газар эзэмших
Чингэлтэй дүүрэг	**Сүхбаатар дүүрэг**	**Налайх дүүрэг**	**Багануур дүүрэг**	**Багахангай дүүрэг**
Орон сууц, газар эзэмших	Орон сууц, газар эзэмших	Хөдөлмөр эрхлэлт	Боловсрол	Хөдөлмөр эрхлэлт
Боловсрол	Боловсрол	Боловсрол	Хөдөлмөр эрхлэлт	Гэр бүл

1.5 ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ

Зураг 19. Хөдөлмөр эрхлэлтийн үндсэн салбарууд (эзлэх хувь)



Энэ удаагийн үнэлгээгээр Улаанбаатар хотын хэмжээнд хөдөлмөр эрхлэлтийн үндсэн салбар нийгмийн ажил болсныг хэсгүүдийн 28 хувь мэдээлжээ. Мөн түүнчлэн барилгын салбар хөдөлмөр эрхлэлтийн үндсэн салбарын нэг (хэсгүүдийн 24 хувийн мэдээлснээр) хэвээр байсан бол үүний араас бөөний болон жижиглэнгийн худалдааг (хэсгүүдийн 15 хувийн мэдээлснээр) нэрлэсэн байна.

Хүснэгт 3. Хөдөлмөр эрхлэлтийн үндсэн салбарууд, дүүргээр (хэсэгт эзлэх хувь)

Нийт	Баянзүрх дүүрэг	Сонгинохайрхан дүүрэг	Баянгол дүүрэг	Хан-Уул дүүрэг
Нийгмийн ажил (28%) Барилга (24%)	Нийгмийн ажил (27%) Барилга (22%)	Барилга (36%) Нийгмийн ажил (29%)	Бөөний болон жижиглэн худалдаа (26%) Нийгмийн ажил (22%)	Нийгмийн ажил (30%) Барилга (25%)
Чингэлтэй дүүрэг	**Сүхбаатар дүүрэг**	**Налайх дүүрэг**	**Багануур дүүрэг**	**Багахангай дүүрэг**
Нийгмийн ажил (33%) Барилга (24%)	Нийгмийн ажил (32%) Барилга (26%)	Нийгмийн ажил (34%) Боловсрол (12%)	Уул уурхайн олборлолт (29%) Төрийн удирдлага ба батлан хамгаалах (18%)	Мал маллах (33%) Нийгмийн ажил (17%)

1.6 САНХҮҮГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

Зураг 20. Орлогын үндсэн эх үүсвэр (эзлэх хувь)

Улаанбаатар хотын бүх дүүргүүдэд орлогын үндсэн эх үүсвэр нь хөдөлмөр эрхлэлт гэж мэдээлсэн ба энэ үзүүлэлт хэсгүүдийн 87 хувьд зонхилж байна. Түүнчлэн орлогын бусад зонхилох эх үүсвэрт тэтгэвэр (хэсгүүдийн 5 хувийн мэдээлснээр), ББСБ болон банкны зээл (3 хувь) оржээ. Харин нийт хэсгүүдийн 1 хувь буюу 26 хэсэгт дийлэнх оршин суугчдынх нь орлогын үндсэн эх үүсвэр нь төрийн болон ТББ-аас өгдөг халамж, тусламж гэсэн мэдээлэл өгсөн байна. Эдгээр хэсгүүд нь Налайх (хэсгүүдийн 3 хувь), Чингэлтэй (5 хувь) дүүрэгт байсан.

Хүснэгт 4. Орлогын үндсэн эх үүсвэр (дүүгээр)

	Хөдөлмөр эрхлэлт	Тэтгэвэр	ББСБ, банкны зээл	Байшин, газраас авсан түрээс	Төрийн болон ТББ-аас өгдөг халамж, тусламж
Нийт	87%	5%	3%	2%	1%
Баянзүрх дүүрэг	88%	5%	2%	2%	1%
Сонгинохайрхан дүүрэг	87%	5%	5%	1%	1%
Баянгол дүүрэг	88%	6%	1%	3%	1%
Хан-Уул дүүрэг	88%	6%	2%	2%	1%
Чингэлтэй дүүрэг	84%	3%	4%	3%	3%
Сүхбаатар дүүрэг	89%	7%	2%	1%	0%
Налайх дүүрэг	88%	2%	4%	0%	6%
Багануур дүүрэг	79%	21%	0%	0%	0%
Багахангай дүүрэг	100%	0%	0%	0%	0%

Зураг 21. Хүнсний хэрэглээгээ багасгасан (эзлэх хувь)



Хүнсний хэрэглээ мэдэгдэхүйц хэмжээгээр буюу хэсгүүдийн 66 хувьд хүрч буурсан нь өмнөх үнэлгээний 68 хувь гэсэн үзүүлэлтээс бага зэрэг буурсан байна. Нийт 168 хэсэгт хүнсний хэрэглээ тогтмол байдлаар буурсан (хэсгүүдийн 9 хувь) ба энэ нь Улаанбаатар хотын хэмжээнд нийтдээ 158,000 иргэн буюу хотын нийт хүн амын 10 хувьд нөлөөлжээ. Сонгинохайрхан дүүрэгт хамгийн олон хэсэг (59 хэсэг буюу тус дүүргийн нийт хэсгийн 15 хувь) хүнсний хэрэглээгээ мэдэгдэхүйц тогтмол байдлаар бууруулсан үзүүлэлттэй байна.

Хүснэгт 5. Хүнсний хэрэглээгээ тогтмол байдлаар бууруулсан хэсгүүд (дүүргээр)

Нийт	Баянзүрх дүүрэг	Сонгинохайрхан дүүрэг	Баянгол дүүрэг	Хан-Уул дүүрэг
168 хэсэг (хэсгүүдийн 9 хувь)	34 хэсэг (хэсгүүдийн 7 хувь)	59 хэсэг (хэсгүүдийн 15 хувь)	15 хэсэг (хэсгүүдийн 6 хувь)	15 хэсэг (хэсгүүдийн 7 хувь)
Чингэлтэй дүүрэг	**Сүхбаатар дүүрэг**	**Налайх дүүрэг**	**Багануур дүүрэг**	**Багахангай дүүрэг**
26 хэсэг (хэсгүүдийн 12 хувь)	13 хэсэг (хэсгүүдийн 7 хувь)	3 хэсэг (хэсгүүдийн 6 хувь)	3 хэсэг (хэсгүүдийн 9 хувь)	0 хэсэг

1.7 ШИЛЖИЛТ ХӨДӨЛГӨӨНТЭЙ ХОЛБООТОЙ ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДЛУУД

Бүдүүвч 8. Шижлилт хөдөлгөөнтэй холбоотой тулгамдаж буй асуудлуудыг мэдээлсэн хэсгүүд (эзлэх хувь)



Улаанбаатар хотын нийт хэсгүүдийн 73 хувь нь нийслэлд шилжин ирж буй иргэдийн нөлөөллөөс улбаатай хамгийн ихээр тулгамддаг багадаа нэг төрлийн асуудал байгаа гэж мэдээлсэн бол 8 хувь нь тухайн хэсэгт тулгамдсан асуудал байхгүй, 19 хувь нь мэдэхгүй гэж мэдээлжээ. Боловсролын үйлчилгээний ачаалал хамгийн ихээр тулгамддаг асуудал (25 хувийн мэдээлснээр) хэвээр байсан ба энэ нь 486,000 иргэнд нөлөөлж байна (хүн амын 30 хувь). Өмнөх үнэлгээгээр 16 хувь байсан эрүүл мэндийн үйлчилгээний ачаалал нэрлэсэн сорилт нь энэ удаагийн үнэлгээгээр 20 хувь болж 359,000 иргэнд (хүн амын 22 хувь) нөлөөлж байна. Түүнчлэн нийт хэсгүүдийн 18 хувь нь агаарын бохирдол гэсэн асуудлыг мэдээлсэн нь өмнөх үнэлгээний 13 хувь байсан үзүүлэлтээс өссөн харагдаж байна.

Зураг 22. Шилжилт хөдөлгөөнтэй холбоотой тулгамдаж буй асуудлууд (эзлэх хувь)

Хүснэгт 6. Ирсэн хөдөлгөөнтэй холбоотой тулгамдаж буй асуудлууд (дүүргээр)

	Боловсролын хүртээмж	Эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж	Агаарын бохирдол	Байгаль орчны бохирдол	Замын хөдөлгөөн түгжрэл	Гэмт хэрэг	Нийгмийн чиг хандлага	Цөлжилт
Нийт	25%	20%	18%	15%	13%	4%	2%	1%
Баянзүрх дүүрэг	27%	20%	19%	12%	16%	2%	2%	0%
Сонгино-хайрхан дүүрэг	21%	23%	18%	17%	9%	8%	2%	1%
Баянгол дүүрэг	25%	22%	14%	15%	15%	5%	2%	0%
Хан-Уул дүүрэг	27%	14%	24%	11%	21%	1%	1%	0%
Чингэлтэй дүүрэг	24%	23%	17%	21%	8%	3%	2%	1%
Сүхбаатар дүүрэг	35%	16%	17%	15%	10%	5%	1%	0%
Налайх дүүрэг	23%	17%	19%	21%	4%	12%	2%	0%
Багануур дүүрэг	8%	17%	28%	6%	25%	8%	8%	0%
Багахангай дүүрэг	0%	0%	0%	100%	0%	0%	0%	0%

Улаанбаатар хотын хэмжээнд хэсгүүдийн 86 хувь нь засаг захиргааны нэгжээс шилжилт хөдөлгөөнтэй холбоотой тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх арга хэмжээг авч ажилласан гэж мэдээлсэн бол 14 хувь нь ямар ч арга хэмжээ авч ажиллаагүй гэж мэдээлжээ (Дэлгэрэнгүйг хавсралтаас харна уу). Засаг захиргаанаас одоогийн байдлаар авч хэрэгжүүлж буй арга хэмжээнүүдээс гадна богино хугацааны хөдөлгөөнийг бүртгэх эрх зүйн орчныг сайжруулах (гол мэдээлэгчдийн 59 хувь), улмаар төвлөрсөн бүсийн орох, гарах хөдөлгөөнд тавих хяналтыг сайжруулах (гол мэдээлэгчдийн 22 хувь) асуудлыг эрх баригчид анхаарах нь зүйтэй гэж гол мэдээлэгчид үзсэн байна.

Бүдүүвч 9. **Засаг захиргааны нэгжээс арга хэмжээ авч байгаа эсэх (эзлэх хувь)**



Зураг 23. **Шилжилт хөдөлгөөнтэй холбоотой тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх боломжтой бусад арга хэмжээ (эзлэх хувь)**

1.8 ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХҮРТЭЭМЖ БА ДЭД БҮТЭЦ

Улаанбаатар хотын хэмжээнд иргэдэд хамгийн хүндрэлтэй байгаа асуудлаар орлогоо нэмэгдүүлэх боломж бололцооны хомсдол (хэсгүүдийн 19 хувийн мэдээлснээр), эрүүл мэндийн барилга байгууламж, тусламж үйлчилгээний ачаалал (16 хувь), машины зогсоол (13 хувь), боловсролын үйлчилгээний ачаалал (14 хувь) гэсэн асуудлыг нэрлэсэн байна. Машины зогсоолыг хамгийн хүндрэлтэй байгаа асуудлаар нэрлэсэн Баянгол дүүргээс бусад бүх дүүргүүдэд орлогоо нэмэгдүүлэх боломж бололцооны хомсдолыг хамгийн хүндрэлтэй асуудлаар нэрлэжээ. Эдгээр үр дүнг өмнөх судалгааны үр дүнтэй харьцуулж үзэх нь зүйтэй.

Зураг 24. **Хангалттай хүртээмжгүй байгаа үйлчилгээ (эзлэх хувь)**



Хүснэгт 7. Иргэдэд хүртээмжгүй байгаа үндсэн үйлчилгээ болон дэд бүтэц (дүүргээр)

	Орлогоо нэмэгдүүлэх боломж	Эрүүл мэнд	Машины зогсоол	Боловсрол	Орон байр
Нийт	19%	16%	14%	13%	8%
Баянзүрх дүүрэг	18%	18%	15%	14%	7%
Сонгинохайрхан дүүрэг	21%	14%	10%	10%	9%
Баянгол дүүрэг	19%	18%	21%	16%	7%
Хан-Уул дүүрэг	16%	14%	11%	14%	9%
Чингэлтэй дүүрэг	21%	16%	11%	9%	11%
Сүхбаатар дүүрэг	20%	17%	17%	15%	9%
Налайх дүүрэг	22%	15%	10%	8%	7%
Багануур дүүрэг	28%	16%	10%	6%	8%
Багахангай дүүрэг	18%	18%	6%	6%	24%

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд тулгамдаж буй үндсэн бэрхшээлээр нийтийн эзэмшлийн зам, талбай, барилга байгууламжид аюулгүй нэвтрэхэд шаардлагатай дэд бүтцийн дутмаг байдлыг (хэсгүүдийн 37 хувь мэдээлсэн) нэрлэсэн бол үүний араас тусгайлсан эмнэлгийн тусламж үйлчилгээ (24 хувь), тусгайлсан тээврийн үйлчилгээ (21 хувь) орсон байна.

Зураг 25. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд тулгамдаж буй асуудлууд (эзлэх хувь)



Хүснэгт 8. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд тулгамдаж буй асуудал, дүүргээр

	Нийтийн эзэмшлийн талбайд аюулгүй нэвтрэх дэд бүтэц	Тусгайлсан эмнэлгийн тусламж үйлчилгээ	Тусгайлсан тээврийн үйлчилгээ	Тусгайлсан боловсролын үйлчилгээ	Сорилт байхгүй	Бусад
Нийт	**37%**	**24%**	**21%**	**15%**	**2%**	**1%**
Баянзүрх дүүрэг	36%	22%	22%	13%	0%	2%
Сонгинохайрхан дүүрэг	33%	23%	25%	10%	1%	3%
Баянгол дүүрэг	43%	25%	13%	17%	0%	0%
Хан-Уул дүүрэг	43%	23%	23%	8%	2%	2%
Чингэлтэй дүүрэг	32%	31%	22%	12%	2%	1%
Сүхбаатар дүүрэг	46%	22%	15%	15%	0%	1%
Налайх дүүрэг	13%	33%	36%	15%	1%	1%
Багануур дүүрэг	26%	19%	26%	28%	2%	0%
Багахангай дүүрэг	0%	43%	43%	14%	0%	0%

ДҮГНЭЛТ БА ЗӨВЛӨМЖ

ДҮГНЭЛТ

Гуравдугаар ээлжийн тоон мэдээлэл нэгтгэлийн гол үр дүн нь хоёрдугаар ээлжийн тоон мэдээлэл нэгтгэлийн үр дүнтэй, ялангуяа Улаанбаатар хот руу шилжин ирэх, хотоос шилжин явах хөдөлгөөний чиг хандлага, нийгэм эдийн засгийн сорилттой нийцэж байна.

Орлогоо нэмэгдүүлэх боломж бололцооны дутмаг байдал өмнөх үнэлгээний үр дүнтэй адил үндсэн сорилт хэвээр байна. Судалгааны тоон мэдээллээс харвал уг сорилт нь хүнсний аюулгүй байдалд мэдэгдэхүйц түвшинд сөрөг нөлөөлөл үзүүлж байна. Хэдийгээр хүнсний хэрэглээгээ тогтмол байдлаар бууруулах үзэгдэл нь буурах чиг хандлагатай байгаа ч Улаанбаатар хотын нийт хэсгүүдийн талаас илүү буюу 66 хувь нь хүнсний хэрэглээгээ тогтмол байдлаар бууруулсан гэж мэдээлсэн. Түүнчлэн эдгээр хэсгүүдийн дийлэнх нь орлогоо нэмэгдүүлэх боломж бололцоо хомс байна гэж мэдээлсэн байна. Нийт дүүргүүдээс Сонгинохайрхан дүүрэг хүнсний аюулгүй байдлыг хамгийн хурцадмал асуудал гэж нэрлэсэн ба тус дүүргийн 15 хэсэг хүнсний хэрэглээгээ тогтмол байдлаар багасгасан үзүүлэлттэй байна.

Боловсролын үйлчилгээний ачаалал, боловсролын барилга байгууламжийн дутмаг байдал нь Улаанбаатар хотод тулгамдаж буй бас нэгэн том бэрхшээл хэвээр байгаа бөгөөд энэ нь нийслэл хот доторх шилжилт хөдөлгөөнд нөлөөлөл үзүүлж байна. Нийт хэсгүүдийн хэмжээнд шилжин явах ба шилжин ирэх хөдөлгөөний зонхилох үндсэн шалтгаан нь боловсрол байгааг хоёрдугаар ба гуравдугаар ээлжийн тоон мэдээлэл нэгтгэлийн үр дүн харуулж байна.

Түүнчлэн эрүүл мэндийн үйлчилгээний ачаалал нь шилжилт хөдөлгөөний төлөвт нөлөөлж болзошгүй байгааг дурдах нь зүйтэй. Өнөөгийн байдлаар, хотын хэмжээнд шилжин ирэгсдийн 14 хувь, шилжин явагсдын 13 хувь эрүүл мэндийн тусламж үйлчилгээ гэсэн үндсэн шалтгаанаар шилжилт хөдөлгөөнд оролцох шийдвэр гаргасан байна. Үүнтэй зэрэгцээд хэсгүүдийн тал буюу 46 хувийн мэдээлснээр эрүүл мэндийн тусламж үйлчилгээний ачаалал нь хотын хэмжээнд тулгамдаж буй хамгийн том бэрхшээл байна. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хомсдол нь эрүүл мэнд муудах, нийгмийн нягтрал багасах зэрэг сөрөг нөлөө үзүүлж болзошгүйг анхаарах нь зүйтэй.

ЗӨВЛӨМЖ

- Улаанбаатар хотын хэмжээнд орлогоо нэмэгдүүлэх боломж хомс байх нь зонхилох бэрхшээл байсан. Дотоодын эдийн засгийг идэвхжүүлэх, нэн ялангуяа хувийн хэвшлийг идэвхжүүлэх замаар иргэдэд дэмжлэг үзүүлэх нь чухал. Аж үйлдвэрийн салбараас бусад салбаруудад жижиг, дунд бизнесүүдийг бий болгох, хөгжүүлэхэд санхүүгийн дэмжлэг үзүүлж дэмжихийг зөвлөж байна. Ингэхдээ оршин суугчдынх нь дийлэнх нь төрийн болон ТББ-аас тусламж, халамжийг орлогын үндсэн эх үүсвэрээ болгоод буй хэсгүүдэд онцгой анхаарал хандуулах нь зүйтэй юм.
- Эмзэг бүлгийн өрхүүдийн амьдралын үндсэн хэрэгцээг хангахын тулд хүнсний багц тараах зэрэг богино хугацааны зорилтот тусламжийг хамгийн эмзэг/нэн ядуу өрхүүдэд үзүүлэх нь зүйтэй. Ингэхдээ хүнсний хэрэглээгээ тогтмол байдлаар бууруулсан хамгийн олон өрхтэй Сонгинохайрхан дүүрэгт онцгой анхаарал хандуулах нь зүйтэй гэж харагдаж байна.
- Бүх дүүргүүдийн боловсролын барилга байгууламжийн нөхцөл байдлыг сайжруулах, сургалтын чанарыг бэхжүүлэхэд тулгамдаж буй саад бэрхшээлийг ойлгохын тулд илүү өргөн хүрээний судалгаа хийх нь зүйтэй юм.
- Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний ачааллын шилжилт хөдөлгөөний чиг хандлага болон шилжин суурьшигчдын сайн сайхан байдалд үзүүлэх нөлөөллийг илүү дэлгэрэнгүй судалж, судалгааны үр дүнгээс хамааран үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх нь зүйтэй.

Уг тайлангийн үр дүн, дүгнэлт нь зөвхөн судалгааны багийн байр суурийг илэрхийлэх бөгөөд ОУШХБ, түүний гишүүн улсууд, Швейцарын хөгжлийг агентлаг болон бусад хандивлагчдын байр суурийг илэрхийлэхгүй болно. Тайлангийн туршид ашигласан тэмдэглэгээ болон материалын танилцуулга нь аливаа улс орон, нутаг дэвсгэр, хот, бүс нутгийн эрх зүйн байдлын талаар ОУШХБ-ын зүгээс ямар нэгэн үзэл бодол илэрхийлэх, эсхүл түүний эрх баригчид, хил хязгаарыг илэрхийлээгүй болно.

ОУШХБ нь шилжин суурьшигчид, хөдөлгөөнт хүн ам болон нийгэмд тустай, хүмүүнлэг, аюулгүй, цэгцтэй шилжилт хөдөлгөөний зарчмыг баримтлан ажилладаг. ОУШХБ нь засгийн газар хоорондын байгууллага, олон улсын хамтын нийгэмлэгийн түншүүдтэйгээ дараах зорилтын хүрээнд хамтран ажилладаг. Үүнд: Шилжилт хөдөлгөөний үйл явц дахь сорилтыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх, шилжилт хөдөлгөөний асуудлын талаар мэдлэг мэдээллээ дээшлүүлэх, шилжилт хөдөлгөөнөөр дамжуулан нийгэм, эдийн засгийн хөгжлийг дэмжих, мөн шилжин суурьшигчдын нэр төр, сайн сайхныг дээдлэх зэрэг болно.

Энэхүү тайлан нь Швейцарын хөгжлийн агентлагийн санхүүжилттэйгээр, ОУШХБ-аас хэрэгжүүлж буй "Монгол Улс дахь дотоод шилжилт хөдөлгөөнийг ойлгож, удирдах нь" төслийн хүрээнд хийгдэж буй ажлуудаас гаргаж буй үр дүнгийн нэг хэсэг юм. Энэхүү төслийн зорилго нь Хүн амын Хөдөлгөөнийг Тандах Матрицыг (ДТМ) ашиглан Монгол Улсын дотоод шилжилт хөдөлгөөн, хөгжлийн бодлогыг тууштай хэрэгжүүлэх замаар нотолгоонд суурилсан томьёолол, хэрэгжилтийг бэхжүүлэн бататгахад оршино. Тайланг загварчлах ажлыг Ямэй Дү, дотоодын зөвлөх Ганбатын Гэрэлтогтохын хамт боловсруулсан болно. Судалгааны асуулгын загварчлалыг ОУШХБ-ын ДТМ-ын баг, НЗДТГ-ын оролцоотойгоор боловсруулсан байна. Судалгааны мэдээллийг ОУШХБ-ын Ази, Номхон далайн бүс нутгийн алба болон Глобал ДТМ-ыг дэмжих багийн техникийн дэмжлэгтэйгээр Хүн амын Хөдөлгөөнийг Тандах Матрицын (ДТМ) хэрэглүүрийг ашиглан цуглуулж, дүн шинжилгээ хийсэн болно.

DTM
IOM DISPLACEMENT TRACKING MATRIX

IOM
UN MIGRATION

Schweizerische Eidgenossenschaft
Confédération suisse
Confederazione Svizzera
Confederaziun svizra

Swiss Agency for Development and Cooperation SDC
Швейцарын хөгжлийн агентлаг